

## **“НООЛУУР ХӨТӨЛБӨР” (2018-2021)**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

#### **1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 114 дүгээр тогтоолоор анх баталсан “Ноолуур хөтөлбөр”-ийг 2000-2004 онуудад хэрэгжүүлсэний үр дүнд улсын хэмжээнд бэлтгэж буй ноолуурын нөөцийн 88 хувийг гүйцэт боловсруулж, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, экспорт эрчимтэй өсч, тухайн үеийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмрийг оруулсан байдаг.

Үндэсний статистикийн хорооны 2016 оны мэдээгээр улсын хэмжээний ноолуурын нөөцийн 12 хувийг дотооддоо гүн боловсруулж, аж үйлдвэрийн салбарын 2,3 хувь, боловсруулах үйлдвэрийн салбарын 7 хувь, хөнгөн үйлдвэрийн салбарын 50 гаруй хувийг тус тус эзэлж байгаа нь цаашид ноолуурын үйлдвэрлэл Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй болохыг харуулж байна.

Ноолуурын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх нь манай улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээр байгаа боловч, эрхзүй, эдийн засгийн хүндрэлээс шалгаалан нийт нөөцийн 80 гаруй хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн байдлаар экспортод гарч, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа зэрэг тулгамдсан асуудал бий болсон.

Өмнө хэрэгжүүлсэн Ноолуур хөтөлбөрүүдийн эерэг үр дүн, сургамж болон ноолуурын салбарт 2011-2015 онд бий болсон хууль эрх зүйн таатай орчинд тулгуурлан ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, ноолуурын үйлдвэрлэлийн талаар Засгийн газраас баримтлах цаашдын зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт ноолуурын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар улс эх орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтууд тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

2.1 Хөтөлбөрийн зорилго нь түүхий эдийн чанартай уялдуулсан бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэн бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд

хүргэж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж салбарын тогтвортой хөгжлийг бий болгоход оршино.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

3.1 Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

3.1.1. бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх;

3.1.2. байгальд ээлтэй, гарал үүсэл нь баталгаатай, чанартай түүхий эдийг үйлдвэрлэлд тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

3.1.3. ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэвшилтэт техник, технологийг нутагшуулж, ээлтэй, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх.

### **Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1. Гаалийн болон Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ноос, ноолуурын үйлдвэрүүдийн дотоодын хамтын ажиллагааг дэмжих, түүхийгээр гадагшаа чиглэсэн урсгалыг бууруулах.

4.1.2. ноолуурын боловсруулалтын түвшинг ахиулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд зориулан хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, “Ноолуурын хөгжил сан” –ийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

4.1.3. нарийн ноолуурыг ангилж, үйлдвэрт тушаасан малчинд чанараас хамаарсан нэг удаагийн урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэх;

4.1.4. боловсруулалтын түвшнээс хамаарч экспортын хураамж авдаг тогтолцоог бүрдүүлж, өөрийгөө санхүүжүүлэх механизмыг бий болгон ноолуурын хөгжлийн санд төвлөрүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

4.1.5. ноолуурын өртгийн сүлжээнд хамрагдсан үйлдвэрлэл, худалдааг бүртгэлжүүлэн хөгжүүлэх;

4.2. Байгальд ээлтэй, гарал үүсэл нь баталгаатай, чанартай түүхий эдийг үйлдвэрлэлд тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. байгаль орчин болон ноолуурын чанарт муугаар нөлөөлж буй сүргийн бүтцийг зохистой болгох, гарал үүсэл нь тодорхой, стандартын шаардлага хангасан ямааг сайжруулагчаар ашиглан ноолуурын чанарыг сайжруулах, ноолуурыг чанараар нь ангилан бэлтгэх тогтолцоог бий болгох;

4.2.2. малын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, орон нутагт малын эрүүл, аюулгүй бүс бий болгож, баталгаажуулж, арилжаанд үнэлэмж нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.2.3. ямааны үүлдэр омог, тархац, ноолуурын шинж чанарын бүсчилсэн судалгааг явуулж, өгөгдлийн баазыг байнга шинэчилж, судалгаа болон үйлдвэрлэлд ашиглах нөхцөл бүрдүүлэх;

4.2.4. сумыг биеэ даан түүхий эдийг хүлээн авч, чанар стандартын дагуу бэлтгэн биржээр арилжаалдаг хоршооны болон аж ахуйн нэгжийн хэлбэрт шилжүүлэх талаар судалж, шийдвэрлэх;

4.2.5. тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор бэлчээрийг хамгаалах, ойжуулах, усжуулах чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын оролцоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг дэмжих;

4.3. Ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэвшилтэт техник, технологийг нутагшуулж, ээлтэй, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын зориулалттай “Ноолуурын хөгжил сан” –д 500 хүртэл тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх;

4.3.2. ноолуурын боловсруулалтын түвшин, өртөг шингэсэн байдлаас хамаарч 3-аас доошгүй жилийн хугацаатай эргэлтийн, 10-аас доошгүй жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийн дэмжлэг үзүүлэх;

4.3.3. ноолууран ээрмэл утасны үйлдвэр байгуулах, өргөжүүлэхийг дэмжих;

4.3.4. ноолууран бүтээгдэхүүний хэрэглээний хандлагын мэдээллийн бааз бүрдүүлэх, гадаад, дотоодын зорилтот зах зээлийн системтэй тандан судалгааг хөгжүүлэх;

4.3.5. монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, “Монголын Хаан Ширхэгт” брэндийг хөгжүүлж, олон улсын хэмжээнд байр сууриа бэхжүүлэх;

4.3.6. хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүй, чанар аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

4.3.7. чанарын сорилт, судалгааны лаборатори, хүний нөөцийг чадавхжуулж, олон улсын түвшний сорилт баталгаажуулалтын тогтолцоо, үйлчилгээг үе шаттайгаар бий болгох;

4.3.8. сүлжмэл, нэхмэлийн жижиг, дунд үйлдвэрүүдийг кластерийн зохион байгуулалтад оруулж, нэгдсэн захиалга, борлуулалтын үйл ажиллагааг эрхлэх нэгжийг бий болгон хөгжүүлнэ.

4.3.9. боловсруулах үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн инженер мэргэжлүүдийг Монгол улсад эрэлттэй 20 мэргэжилд хамруулж, тэтгэлэгтэй болгох;

4.3.10. удам дагасан мэргэжилтэн бэлтгэх судалгаа хийж, нарийн мэргэжлийн ажилтануудын шаталсан сургалтыг бодлогоор дэмжих;

4.3.11. үйлдвэрлэлийн загвар дизайн, кластерийг хөгжүүлэх зорилгоор технологи дамжуулах төв, загварын студиог мэргэжлийн холбоог түшиглэн хөгжүүлэх;

4.3.12. олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилтот үзэсгэлэн яармаг, бизнес форумд тогтмол оролцох, зохион байгуулахыг дэмжих;

### **Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

5.1. Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн хугацаанд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлэх замаар түүхий эдийн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 4,8 дахин нэмэгдүүлнэ.

5.3.Ээрмэл утас үйлдвэрлэлийг 3-3,5 дахин өсгөж, олон улсын зах зээлд шууд борлуулах боломж бүрдсэн байна;

5.4. Ноолуурын салбарт олгох хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нөхцөл сайжирсан байна.

5.5. “Монголын Хаан Ширхэгт” чанарын гэрчлэх тэмдэг бүхий байгальд ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг бий болгож, дотоод гадаадын зах зээлд таниулсан байна.

5.6. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сорилт, судалгааны хүрээлэнтэй болсон байна.

5.7. Мэргэжлийн холбоог түшиглэсэн технологи дамжуулах төв, хувцас загварын үйлчилгээний төв бий болсон байна.

5.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр нэхмэлийн салбарт нийт 10 мянга гаруй ажлын байр тогтвортой хадгалагдаж, 3600 гаруй ажлын байр шинээр бий болж, эцсийн бүтээгдэхүүний экспорт 5,01 дахин өссөн байна.

| № | Үзүүлэлт   | Суурь түвшин (2016 он) | Зорилтот түвшин (2022 он) |
|---|--|------------------------|---------------------------|
| 1 | Ажлын байр /байнгын болон гэрээт ажилтан/            | 10000                  | 13600                     |
| 2 | Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /тэрбум/           | 203                    | 1000                      |
| 3 | Экспорт /нийт үйлдвэрлэлтийн %/                      | 70                     | 90                        |
| 4 | Дотоодын үйлдвэрүүдийн бэлтгэх ноолуурын хэмжээ /тн/ | 1200                   | 5400                      |

5.9.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

| № | Үзүүлэлт  | Хэмжих нэгж | Суурь түвшин (2016 он) | Зорилтот түвшин (2021 он) |
|---|---|-------------|------------------------|---------------------------|
| 1 | Угаасан ноолуур                                   | тн          | 6500                   | 6500                      |
| 2 | Самнасан ноолуур дотоодын үйлдвэрийн зориулалтаар | тн          | 900                    | 4700                      |
| 3 | Ээрмэл  | тн          | 450                    | 2000                      |
| 4 | Сүлжмэл   | Мя.ш        | 812                    | 3200                      |
| 5 | Нэхмэл  | Тууш.метр   | 500                    | 1500                      |
| 6 | Ажлын байрны тоо /байнгын/                        | хүн         | 5600                   | 13600                     |

## **Зургаа.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөлийг хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

6.2.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яамны удирдах албан тушаалтан, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл оролцох бөгөөд зөвлөлийн гишүүдийг Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

6.3.Хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөлийг мэргэжлийн холбоодын дэргэд ажиллуулж холбогдох байгууллагууд хувийн хэвшлийн төлөөлөл орж ажиллана.

6.4.Сум, дүүргийн иргэдийн Хурал, Засаг дарга нь түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт**

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 7.1.1. аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө оруулалт;
- 7.1.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;
- 7.1.3. гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт;
- 7.1.4. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 7.1.5. зээл болон бондын эх үүсвэр;
- 7.1.6. Монголбанк болон Хөгжлийн банкны эх үүсвэр.

## **Найм. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

8.1.Төрийн захиргааны төв байгууллага үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

8.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.